



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 4/123

Улаанбаатар хот

Донороос эд, эрхтэн авах, хадгалах,
тээвэрлэх, устгах журам батлах тухай

Донорын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ
нь:

1. Донороос эд, эрхтэн авах, хадгалах, тээвэрлэх, устгах журмыг нэгдүгээр, Шилжүүлэн суулгах эд, эрхтнийг өгөх зөвшөөрлийн хуудсыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Улсын нэгдүгээр төв эмнэлэг /Б.Бямбадорж/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 233 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080406

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 03 сарын 31-ны өдрийн
А... дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

Донороос эд, эрхтэн авах, хадгалах, тээвэрлэх, устгах журам

Нэг.Амьд донороос эд, эрхтэн авах

- 1.1.Амьд донороос эд, эрхтэн авахын өмнө зөвшөөрлийг бичгээр авсан байна.
- 1.2.Эд, эрхтэн авахын өмнө эдийн тохирооны шинжилгээг хийж реципиентэд тохирох эсэхийг тогтооно.
- 1.3.Амьд донороос эд, эрхтнийг ерөнхий мэдээ алдуулалтын дор авна.
- 1.4.Эд, эрхтэнг холбогдох зааврын дагуу авах явцдаа ойр орчмын эд, эрхтний үйл ажиллагааг алдагдуулахгүй байх, донор хамгаалах зарчмыг баримтална.

Хоёр.Амьгүй донороос эд, эрхтэн авах

- 2.1.Эд, эрхтнийг цогцсоос авахдаа холбогдох зааврын дагуу авна.
- 2.2.Судсаар тэжээгдэх эд, эрхтнийг тэжээгч болон тараагуур судас, түүний салаануудыг залгаас хийхэд хангалттай хэмжээгээр авч болохуйц мэс заслын хүрцийг сонгож болно.
- 2.3.Амьгүй донорын мэс заслын бэлтгэлийг донор байрлаж буй эмнэлэг хангана.
- 2.4.Амьгүй донороос эд, эрхтэнг авахдаа дараахь дарааллыг баримтлан авна.
 - 2.4.1.Элэгний баг хэвлийн хөндийг нээж, эрхтэнг чөлөөлнө.
 - 2.4.2.Зүрх, уушигны баг цээжний хөндийг нээж эрхтэн чөлөөлнө.
 - 2.4.3.Нойр булчирхай, бөөрний баг эрхтэнг чөлөөлнө.
 - 2.4.4.Цээж, хэвлийн эрхтнүүдийг угаана.
- 2.5.Эрхтэнг авахдаа зүрх, уушиг, элэг, нойр булчирхай, бөөр, судас, нүдний эвэрлэг гэсэн дарааллаар авна.
- 2.6.Амьгүй донорын байрлаж буй эмнэлгийн мэс заслын баг цогцсыг хэвийн болгон хаана.
- 2.7.Эд, эрхтэн авсан тухай протокол үйлдэж, багийн гишүүд гарын үсэг зурна.
- 2.8.Мэс засал хийх боломжгүй эмнэлэгт амьгүй донор гарвал тээвэрлэнэ.

Гурав.Донор эд, эрхтнийг хадгалах, тээвэрлэх

- 3.1.Шилжүүлэн суулгах эд, эрхтэнг авсан даруйд зориулалтын уусмалд хадгалан эрхтэн зөөвөрлөх мөстэй саванд хийж тээвэрлэнэ.

3.2.Элэг, нойр булчирхайг 4-6 цаг, бөөрийг 36 цаг хадгалж болно.

3.3.Эд, эрхтэн авах багийн эмч донорын эд, эрхтнийг зориулалтын түргэн тусламжийн машинаар тээвэрлэнэ.

3.4.Эд, эрхтнийг тээвэрлэхэд энэхүү журмын 2.7-д заасан протоколыг хавсаргана.

3.5.Эд, эрхтнийг зөөвөрлөхийн өмнө хүлээн авах байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.


Дөрөв.Шаардлага хангаагүй эд, эрхтнийг устгах

4.1.Бэлтгэх, тээвэрлэх, хадгалах, суулгах горим алдагдсан эд, эрхтэн болон уг үйл ажиллагаанд хэрэглэсэн нэг удаагийн багаж, хэрэгслийг хамтад нь устгана.

4.2.Эд, эрхтнийг хэсэгчлэн хэрчиж, бүтцийн бүрэн бүтэн байдлыг эвдэн, эд, эрхтэнг шаардлага хангахгүй тухай протокол үйлдэн, эрхтэн авах багийн ахлагч протоколыг Эмгэг судлалын үндэсний төвд хүлээлгэн өгнө.

4.3.Эмгэг судлалын үндэсний төв нь шаардлага хангахгүй эд, эрхтнийг устгаж, устгасан тухай протоколыг үйлдэнэ.

ooOoo



Эрүүл мэндийн сайдын
2017 оны 03 сарын 31-ны өдрийн
А/ дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

Шилжүүлэн суулгах эд, эрхтнийг өгөх зөвшөөрлийн хуудас

.....овогтой.....ньтархины
эргэшгүй өөрчлөлтөд орсны улмаасэмнэлэгт нас барсан тул түүний
...../эрхтний нэрийг бичнэ/-г бусдын амь нас, эрүүл мэндийг сайжруулах
донорын буянт үйлсэд зориулан авахыг зөвшөөрсөн болно.

1. Донор эд, эрхтэн авахыг зөвшөөрсөн:

ОвогНэр
Нас барагчийн ямар хамаатан болохыг бичнэ.
.....
Гарын үсэг /Гарын үсгийн тайлал/
Зөвшөөрлийг
Онсарөдөрцаг минутадүйлдэв.
Регистрийн дугаар
Эмнэлгийн нэр

2. Гэрч:

ОвогНэр
Ажлын газрын хаяг.....
Регистрийн дугаар
Гарын үсэг /Гарын үсгийн тайлал/